

ХИЛИЙН АЛБАНЫ БОЛОВСРОЛЫН ҮР ДҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ

Л.Лхагвасүрэн

ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн ар тал, эдийн засгийн тэнхимийн дэд

Товч агуулга: Миний судалгааны ажилд цэргийн боловсрол тэр дундаа хилийн албаны боловсролын үүсэл хөгжил, түүнд тавигдах шаардлага болон бусад орны сургалтын харьцуулалтыг харуулж Хилийн албаны сургуулиас цэргийн боловсрол олгох сургалтын үр дүн нь захиалагч байгууллагын хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг гаргах, цэргийн сургалтад хэрэглэж буй гадаадын зарим орны сургалтын хэлбэр, орчныг өөрийн оронд нэвтрүүлэх боломжийг судлан онцлогийг тодорхойлоход оршино

Түлхүүр үгс: Цэрэг, боловсрол, сургалт, хөтөлбөр

Оршил

Монгол улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй шинэ үеийн хил хамгаалах байгууллага үүсэж хөгжсөн хугацаанд хилийн орон зайд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг гардан явуулж байна. Хил хамгаалах байгууллагын салбар, нэгжүүд тэдгээрийн бие бүрэлдэхүүн улсын хил хамгаалах үүргээ хоногийн 24 цагийн турш тасралтгүй хэрэгжүүлж байдаг. Хилчдийг удирдан зохион байгуулж буй төрөл мэргэжлийн офицеруудыг анхлан 1933 онд “Хязгаарын ба гүйцэтгэх ажилтны курс” байгуулагдсанаас эхлэлтэй үүнээс хойш 87 жилийн хугацаанд “Хязгаарын ба гүйцэтгэх ажилтны курс”, Дотоод Явдлын Яамны Төв Сургууль, ДЯЯ-ны Хязгаарын ба дотоодын цэргийн нэгдсэн сургууль, НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургууль, НАХЯ-ны Цэргийн дээд сургууль, Цагдаагийн дээд сургууль /Хилийн албаны тэнхим/, ЦИС-ийн Хилийн факультет /Хилийн сургууль/, ЦИС-ийн Хилийн цэргийн дээд сургууль, БХИС-ийн Хилийн цэргийн дээд сургууль, ХХЕГ-ын харьяа Хилийн цэргийн дээд сургууль, ХСИС-ын

Хилийн албаны сургууль, ДХИС-ийн Хилийн албаны сургууль гэх зэрэг нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан ч үндсэн үүрэг болох Цэргийн офицер бэлтгэх ариун үйлсийг тасралтгүйгээр зохион байгуулж төрлөх сургуулиасаа эрдэмтэн, багш, төр нийгмийн зүтгэлтнүүд, генерал офицеруудыг төрүүлж гаргасаар өдий хүрсэн байна.

Хилийн албаны сургуулийн үндсэн үүрэг нь цэргийн мэргэжлийн офицеруудыг Хилийн алба-Эрх зүй, Хилийн алба, Хилийн Боомтын аюулгүй байдал шалган нэвтрүүлэх албаны ажилтан, Сэтгэл зүйч, Ар тал-Эдийн засаг зэрэг төрөл мэргэжлээр бэлтгэж Хил Хамгаалах Байгууллагын офицерын боловсон хүчнээр хангахад үндсэн үүрэг нь оршиж байдаг. Төрөл мэргэжлийн офицеруудын нийтлэг чанар нь “Цэргийн боловсрол”-ыг системтэйгээр олгоход оршиж байгаа юм. Тэгвэл цэргийн боловсролыг хэрэгжүүлж байсан технологи сургалтын үр дүнгээс шалтгаалан 2017, 2018, 2019 онуудад мэргэжлийн хичээлийн хөтөлбөрүүд хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэл хийгдсэн байна. Учир нь захиалагч байгууллагын шаардлагаар төгсөн гарч буй

бүтээгдэхүүн нь төгсөгчдийн гадаад хэлний мэдлэг, бие бялдрын төвшин, цэргийн хэргийн мэдлэг хангалтгүй байна гэсэн дүгнэлтүүд гарсан тул нийтдээ 3 удаа хөтөлбөрөө шинэчлэлт хийгдсэн байдаг. Цэргийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн суралцахуйн үр дүн нь 3 удаа шинэчлэгдээд байхад захиалагч байгууллагын хүсэмжит үр дүнг хангаж чадахгүй байгаа асуудал нь уг сэдвийг судлах нь нэн тэргүүний чухал зорилт болж байна

Сэдвийн судлагдсан байдал:

Монгол Улсын цэргийн шинжлэх ухааны зарим эрдэмтэд тухайлбал доктор (Ph.D) профессор Ш.Арвай "Монгол Улсын хил хамгаалах салбарын алба байлдааны бэлэн байдал", доктор (Ph.D) профессор Т.Соронзонболд "Цэргийн мэргэжлээр дээд мэргэжил олгох сургалт, стандартыг боловсруулах арга зүйн асуудал", доктор (Ph.D) профессор У.Эрднээ "Ерөнхий зориулалтын цэргийн салаа, салбарын байлдааны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгох асуудал" зэрэг бүтээлүүддээ цэргийн сургалтын онол, практикийн асуудлуудыг тус тус тусгасан байдаг.

Дэлхийн зарим орны цэргийн шинжлэх ухааны эрдэмтэд болох Оросын Холбооны Улсын цэргийн шинжлэх ухааны (Ph.D) профессор Сажин А.И. Эметс В.С нарын "Цэргийн офицерын хувь хүнд чиглэсэн сургалт", Америкийн цэргийн академийн доктор, Александра Димитровска, Славко Анжелески нарын "Цэргийн боловсролын нөлөө үүрэг гүйцэтгэх чадварт нөлөөлөх нөлөөлөл" сэдэвт

бүтээлүүдэд албан хаагчдыг бэлтгэх сургалтын талаар олон талаас нь судлан үзэл онол, загварчлалыг тодорхойлон гаргасан байгаа боловч энэ төрлийн сургалтыг зохион байгуулахад гарч байгаа бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар тийм ч тодорхой бичээгүй байна.

Нэг. Цэргийн боловсролын (түүхэн хөгжил) тухай ойлголт, үзэл санаа

Монгол Улс нь "Мэдлэгт суурилсан" хөгжлийн чиг хандлагыг сонгосон бөгөөд Хил хамгаалах байгууллага/цаашид ХХБ гэх/ ч уг зарчмын дагуу уйл ажиллагаагаа зохион байгуулж явуулах нь зайлшгүй юм. Энэ нь "Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна..."¹ гэж зааснаар баталгаажсан байна.

Сургалтын эцсийн үр дүн нь хунд тухайн чиглэл, зорилгын дагуу боловсрол олгоход чиглэгдэж байдаг. Тиймээс сургалтын онол, арга зүйн асуудлыг нээн гаргах нь боловсролын тухай ойлголтыг тодорхойлохоос эхлэх шаардлагатай юм.

Боловсрол нь их өргөн хүрээтэй ойлголт юм. Шинэ зуунд улс орон хэрхэн хөгжих нь боловсролын шинэчлэлийн чиг хандлага, хурдац, үр дүнгээс хамаарах болж байна.

Цэргийн боловсрол гэдэг нь цэргийн албан хаагчид эх орон, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардагдах мэдлэг,

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал баримт бичгийн 1 дэх хэсэгт

чадварыг эзэмшүүлэх, түүнийг үүссэн ямар ч цагийн байдлын өрнөлтийн үед ашиглах дадлага олгох үйл явц юм.

Монгол Улсын хил хязгаарыг сахин хамгаалах үүргийг тухай үеийн нэршлээр хязгаарын цэрэгт хариуцуулснаар хил хамгаалах мэдлэг чадвар бүхий боловсон хүчин бэлтгэх зорилгоор 1933 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн 08 дугаар тогтоолын дагуу “Дотоод хэргийн газар”-ын харьяа дунд

сургуулийг байгуулснаар “Цэргийн” боловсролын орчин цагийн түүхэн суурь тавигдаж тухайн цаг үеэс эхлэн Цэргийн гэж ямар боловсролтой хүнийг хэлэх вэ хэмээх анхдагч ойлголтууд эхэлсэн болов уу гэж судлаач миний бие үзэж байна.

Орчин цагт цэргийн боловсрол гэж “Бие хүнийг цэргийн алба хаах явцад олж авч байгаа цэргийн эрдэм, хүмүүжил, хөгжил зэрэг олон талт цогц үйл ажиллагааг хэлнэ”¹ хэмээн үзэж байв.

Зураг 1. Төгсөгчдийг жилээр харьцуулсан үзүүлэлт



Судалгаанаас харахад хилийн албаны сургууль нийгмийн аль ч үеүдэд үндсэн зорилго болох Цэргийн офицер, ахлагч бэлтгэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Нийт 3266 гаруй Цэргийн офицерыг бэлтгэж өнөөдрийн байдлаар Хил Хамгаалах Ерөнхий газрын боловсон хүчний 84 хувийн мэргэжлийн боловсон хүчнээр хангаад байна.

Менежментийн талаас нь авч үзвэл: Цэргийн сургуулийн төгсөгч нь амьдрал ахуй, ажил хөдөлмөрөө төлөвлөх, гүйцэтгэх, хянаж шалгах, тодруулж зохицуулахтай холбогдсон мэдлэг

чадвар, төлөвшилтийн цогц үйл хэрэг гэж тайлбарлаж болох юм.

Цэргийн офицер гэж хэн вэ? “Эх орноо хамгаалах үйл ажиллагаанд тусгайлан бэлтгэгдсэн, цэргийн дүрмээр ажиллаж амьдрах үйл хэрэгт сургагдсан, тодорхой хугацаанд заагдсан газар ажиллах, өндөр хариуцлагатай үүрэг хүлээсэн хүнийг хэлнэ” хэмээн үзэж байна.

Цэргийн албан хаагчдыг сургах явцад сурган хүмүүжүүлэх технологид суурилсан ойлголтуудын дараах ангилал нь хамгийн сайн хэрэглээг олсон болно:

- ассоциатив-рефлекс;

¹ “Цэргийн боловсрол” Н.Пүрэвсүрэн, Ш.Доржбал 2004 он 2х

- сэтгэцийн үйлдлийг үе шаттайгаар бүрдүүлэх;
- асуудал ба асуудлын үйл ажиллагааны сурах;
- програмчлагдсан сургалт.

Сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчид, түүний дотор цэргийн шинжлэх ухааны эрдэмтийн хийсэн хэд хэдэн судалгаагаар онолын асуудлыг судлахдаа заахын ассоциатив-рефлекс үзэл баримтлалд суурилсан аргууд илүү үр дүнтэй байдаг бөгөөд ур чадварыг хөгжүүлэхдээ оюун санааны үйл ажиллагааг аажмаар төлөвшүүлэх үзэл баримтлалд суурилсан аргуудыг ашиглах нь зүйтэй юм.

Ассоциатив-рефлекс

сургалтын үзэл баримтлал цэргийн албан хаагчдыг сургахад голчлон хэрэгжүүлдэг. Үүний дагуу дидактик зарчмуудыг боловсруулж, боловсон хүчнийг сургах дийлэнх аргыг боловсруулсан болно.

Энэ нь И.М.Сеченов, И.П.Павлов нарын илрүүлсэн хүний

тархины нөхцөлт рефлексийн үйл ажиллагааны зүй тогтлууд дээр үндэслэдэг; “Энэ нь тархинд кондициональ рефлекс холболт үүсэх байнгын үйл явц юм. Эдгээр нь хувь хүний амьдралын нөхцөл байдлыг илэрхийлдэг. Хувь хүн бүрийн хувийн шинж чанар нь аль холбоо нь тогтвортой, ухамсартаа тогтохоос хамаарна”¹. Тархины болзолт рефлексийн үйл ажиллагааны хэв маягийн тухай И.П.Павловын сургаалд үндэслэн сургалт ба хувь хүний сэтгэцийн хөгжлийн уялдаа холбоогоор Выготский, Оросын сэтгэл судлаач, багш А.Н.Леонтьев, С.Л.Рубинштейн, Д.Б.Елконин, В.В.Давыдов, Н.А.Менчинская, Д.Н.Богоявленский, А. А.Смирнов, Ю.А.Самарин, П.А.Шеварев болон бусад нь заахын ассоциатив-рефлекс ойлголтыг бүрдүүлдэг мэдлэгийг шингээх ажлыг зохион байгуулах янз бүрийн хандлагыг боловсруулсан байдаг.

Хүснэгт 1.Уламжлал ба үр дүнд суурилсан сургалтын ялгаа

Уламжлал	Үр дүнд суурилсан
Багшийн яриа цонхилдог	Сурагчийн дадлага зонхилдог
Сонсож шууд хүртдэг	Аль болох мэдрэхүйн бүх эрхтнээрээ мэдэрч хөгжүүлж хүлээж авдаг
Нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдэж аргаа сонгодог	Хувь хүний хэрэгцээг хангахад чиглэгдэж аргаа сонгодог
1-3 талт үйл ажиллагаа	4-6 талт үйл ажиллагаа

Боловсролын үйл ажиллагаа нь бусадтай адилгүй бөгөөд үүнд хандах бүтээлч хандлагаас гадуур хөгжиж

чадахгүй. Бүтээлч байдал бол жинхэнэ сурган хүмүүжүүлэх арга

¹ Гүзеев В.В., (2004), Образовательная технология: отприёма до философии.

зүй биш бодит бодит хүчилтөрөгч юм.

Цэргийн сургалтын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ /төгсөгч, оюутнууд, ажил олгогч/


Хилийн албаны сургууль нь өнөөгийн байдлаар мэргэжлийн Хилийн албаны тэнхим, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхим, цэргийн хэргийн тэнхим, сэтгэл судлалын тэнхим, ар тал, эдийн засгийн тэнхим, хилийн эрх зүйн тэнхим, инженер техникийн зэрэг нийт 7 тэнхимийн мэргэжлийн 4 хөтөлбөртэйгөөр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Судалгааны зорилго: Цэргийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын үр дүнд шинжилгээ хийж, сайжруулах зарим арга замыг дэвшүүлэн тавих.

Судалгаа авсан газар: Хил хамгаалах ерөнхий газар, Хилийн зарим ангиуд, Дотоод хэргийн их сургууль

Судалгаанд хамрагдсан хүрээ: Хил Хамгаалах Ерөнхий газрын харьяа Хилийн ангиудын захирагч, Хилийн салбарын дарга, орлогч нар

Зураг 2. Төгсөгчдийн ерөнхий үр дүнд өгсөн судалгааны дүн



Мэдээлэл цуглуулах арга зам: Асуулга, ярилцлага, ажиглалт, харьцуулалт

Хил Хамгаалах Ерөнхий газар, Хилийн ангиудын ангийн захирагч, салбарын дарга, орлогч, Дотоод хэргийн их сургуулийн төсөв болон зарим баримт бичгийг харьцуулсан судалгааг нэгтгэн дараах шалгуураар судаллаа: Үүнд

1-р хэсэг: Төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг үнэлнэ үү? гэсэн 13 асуулга бүхий судалгаанд Хил Хамгаалах Ерөнхий газрын харьяа Хилийн 31 ангийн захирагч хамрагдах ёстойгоос 31 оролцогч оролцогч судалгаанд 100 хувь хамрагдаж дараах хариултуудыг өгсөн байна. Асуулга бүрийн харалдаа –Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу, Чухал чанарыг 1-26 хүртэл байр эзлүүлнэ үү- гэсэн хариултууд байна. Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар бүр өөр өөрийн онцлогтой байгаа учраас графикт тоогоор бус тус бүрийг дэлгэрэнгүйгээр үнэлсэн болно. Үүнд:

Судалгаанаас харахад зайлшгүй сайжруулах шаардлагатай төгсөгчдийн үр дүнг дараах байдлаар эрэмбэлж байна. Үүнд

1. Удирдан зохион байгуулах чадвар

2. Ярих илтгэх чадвар


3. Амьд үлдэх чадвар зэрэг үр дүнгүүд шаардлага хангахгүй байна гэж үзсэн байна. Дээрх

шаардлагуудыг хангалттай сайн биш байгаа нь хилийн албаны сургуулийн эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй цаашлаад Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал буюу Монгол Улсын аюулгүй байдлын тухай хуульд зааснаар “Үндэсний аюулгүй байдал”¹ гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” Хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлж буй Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахын тулд хил орчмын бүс нутагт хилийн дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох арга ажиллагаа нь аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг явуулж байгааг хэсэгт чухамдаа дунд түвшний мэдлэгтэй боловсон хүчин очих нь Үндэсний

аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгааг илтгэж байна. Ийм учир Хилийн албаны сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүдийг сайжруулж төгсөгч нараа мэргэжлийн түвшинд бэлтгэх хэрэгтэй гэдэг асуудал тулгарч байна.

2-р хэсэг: Хилийн албаны сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг үнэлнэ үү? гэсэн 9 асуулга бүхий судалгаанд Хил Хамгаалах Ерөнхий газрын харьяа Хилийн 31 ангийн захирагч хамрагдах ёстойгоос 31 оролцогч судалгаанд 100 хувь хамрагдаж дараах хариултуудыг өгсөн байна. 9 асуулга бүхий хүснэгтэн судалгаанд оролцогчид дараах хариултуудыг өгсөн байна. Асуулга бүрийн харалдаа –Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу, Чухал чанарыг 1-10 хүртэл байр эзлүүлнэ үү- гэсэн хариултууд байна. Үүнд:Хилийн албаны сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд өгсөн үнэлгээг нэгтгэн авч үзэхэд дээрх 10 асуулгад давхардсан тоогоор нийт: Маш сайн-1,8%, Сайн-39.6%, Дунд-54.2, Муу-4,5%, Маш муу-0 олонх нь дунд, сайн гэж үнэлжээ.

Зураг 3. Мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй процессыг үнэлэх судалгааны дүн



¹ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль нэгдүгээр бүлэг 3 дугаар зүйл

Захиалагч байгууллагын мэргэжлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд өгсөн судалгаанаас сайжруулах шаардлага ажлыг эрэмбэлэхэд.

1. Сургалтын хөтөлбөрийн агуулга чанар;


2. Сонсогчдын сурах арга барил;

3. Үйлдвэрлэлийн дадлагын үр дүн зэрэг нь хангалттай сайн биш гэж үзсэн байна. Энэ нь хилийн албаны сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүд, сургалт, заах арга зүй, орчны хамаарал харилцан уялдаатай байдаг байна. Судалгаанаас харахад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа буюу мэдлэг олгож буй процессын хувьд дунд түвшинд байгаа нь мэргэжлийн хичээлийн хөтөлбөрүүд

зорилгодоо хүрэх боломж бүрдүүлэх, оюутнууд болон нийгмийн эрэлтийг гүйцэлдүүлэх зорилгоор өөрсдийн хөтөлбөрөө үе шаттайгаар хянаж үнэлж байх шаардлагатай байна. Ийм төрлийн хяналтын ажил шинэчлэлийг хийснээр мэргэжлийн хөтөлбөрийг байнгын сайжруулалт, шинэчлэл рүү хөтлөх юм.

3-р хэсэгт: Төгсөгч нараас авсан судалгаа: *та өөрийнхөө хилийн албаны сургуулиас олж авсан боловсролыг үнэлнэ үү?* гэсэн 2 асуулга бүхий судалгаанд Хилийн албаны сургуулийн 2-4 дүгээр дамжааны 140 сонсогч оролцох ёстойгоос 135 оролцогч оролцогч судалгаанд 99,5 хувь хамрагдаж дараах хариултуудыг өгсөн байна.

Зураг 4. Сонсогчдын хичээлээс авсан үр дүнгээ үнэлэх судалгаа



Хамгийн өндөр хувьтай буюу биеийн тамир, жагсаалын бэлтгэл, цэргийн хэргийн хичээлийг 58.5 хувь нь өөрсдийгөө сайн гэж үзсэн бол гадаад хэл, цэргийн ар тал, албаны амьтдыг хил хамгаалалтад ашиглах, зэвсэг, техник ашиглах чадварын 39.2 хувь нь дунд буюу муу гэсэн хариултыг өгсөн байна. Энэ нь хилийн албаны сургуулийн сонсогч

нар өөрсдийн мэдлэг, чадварыг хангалттай сайн байна гэж үзэж байгаа нь захиалагч байгууллагаас авсан судалгаатай сөрөг үр дагаварт хүрч байна.

Таны судалж буй мэргэжлийн хичээлийн хөтөлбөрт заавал тусгах шаардлагатай сэдвүүд байна уу? Ямар хичээлд, ямар сэдэв, цагийг нэмэх талаар таны бодол:

Зураг 5. Сонсогчдын хөтөлбөрт өгөх санал



Сонсогчдын 69,7 хувь нь цэргийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн бол 29,3 хувь дадлагын цагийг нэмэгдүүлэх гэж үзсэн байна.

4-р хэсэгт: Хилийн албаны сургуулийн төгсөгчдийн албан тушаалын ахиц дэвшлийг тодорхойлох судалгаа сүүлийн 5 жилээр “Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх алба” хөтөлбөрийн жишээн дээр\

2016-2020 онд “Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх алба” мэргэжлээр нийт 43

офицер төгссөн ба 2021 оны 03 дугаар сарын байдлаар Хил хамгаалах байгууллагад 37 офицер ажиллаж байна. Хил хамгаалах байгууллагаас гарсан 7 төгсөгч нь Гадаадын иргэн харьяатын газарт 1, гадаад улсад ажиллаж байгаа 1, хуваариа ажил хөдөлмөр эрхэлж байгаа 2, нас барсан 2 байна.

Тус судалгаанд Хил хамгаалах байгууллагад ажиллаж буй 37 офицeroос 32 офицер /86,4 хувь нь/ хамрагдсан ба төгссөн оноор авч үзвэл 2016 оны 13 төгсөгчөөс 8, 2017 оны 10 төгсөгчөөс 8, 2019 оны 18 төгсөгчөөс 16 офицер хамрагдсан.

Зураг 6.Төгсөгчдийн албан тушаалын ахиц дэвшлийн судалгаа



Судалгаанд хамрагдсан 33 офицер нь 2021 оны 3 сарын байдлаар 10 нэр төрлийн албан тушаал дээр ажиллаж байгаа ба

үүний 20 офицер 62,5 хувь нь шалган нэвтрүүлэх албаны чиглэлээр, 12 офицер 37,5 хувь нь бусад чиглэлээр ажиллаж байна.

Зураг 7. Төгсөгчдийн албан тушаалын ахиц дэвшлийн хувь



Нийт төгсөгчдөөс 16 офицер /50 хувь нь/ ажлын үзүүлэлт тухайн албан тушаалд гаргасан амжилтаараа бусдыгаа манлайлан дараагийн шатны албан тушаалд дэвшиж, 6 офицер /19 хувь нь/ иж шатлалтай албан тушаалд томилогдсон байна.

5-р хэсэгт: Цэргийн мэргэжлийн бэлтгэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаадын

зарим улс орнуудын сургалтад хийсэн ажиглалт судалгаа

Хөрш зэргэлдээ орны ижил мэргэжлийн сургуулийн сургалтын арга хэлбэрийн хувьд Орсын Холбооны Улсын хувьд цэргийн албан хаагчдыг сургах явцад сурган хүмүүжүүлэх технологид суурилсан ойлголтуудын дараах ангилал нь хамгийн сайн хэрэглээг олсон гэж үздэг байна. Үүнд

Хүснэгт 2. Сургалтын харьцуулалт

ОХУ-ын Курган, Калининград хотын Хилийн дээд сургууль	БНХАУ-ын Кунминь хотын Хил, далайн эргийн хамгаалалтын их сургууль	МУ-ын Дотоод Хэргийн Их сургуулийн Хилийн албаны сургууль
Уламжлалт академик сургалт	Уламжлалт академик сургалт	Уламжлалт академик сургалт
Ассоциатив-рефлекс	Ассоциатив-рефлекс	-
Сэтгэцийн үйлдлийг үе шаттайгаар бүрдүүлэх	-	Сэтгэцийн үйлдлийг үе шаттайгаар бүрдүүлэх
Асуудал ба асуудлын үйл ажиллагаанд сургах	-	Асуудал ба асуудлын үйл ажиллагаанд сургах
Програмчлагдсан сургалт	Програмчлагдсан сургалт	Програмчлагдсан сургалт
Практикд суурилсан сургалт	Практикд суурилсан сургалт	Практикд суурилсан сургалт

Судалгаанаас харахад сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчид, түүний дотор цэргийн шинжлэх

ухаанчийн хийсэн хэд хэдэн судалгаагаар онолын асуудлыг судлахдаа заахын ассоциатив-

рефлекс үзэл баримтлалд суурилсан аргууд илүү үр дүнтэй байдаг бөгөөд ур чадварыг хөгжүүлэхдээ оюун санааны үйл ажиллагааг аажмаар төлөвшүүлэх үзэл баримтлалд суурилсан аргуудыг ашиглах нь зүйтэй юм гэж үздэг байна.

Хоёр. Сургалтын үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэх ажиглалт судалгаа


Судалгааны зорилго:
Сургалтын идэвхтэй арга зүй суралцахуйн үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийг ажиглалтын аргаар илрүүлэх

Өнөөдөр сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа ажлын байран дээр ямар мэдлэг, чадвар шаардлагатай байна гэсэн хэрэгцээг нь нарийн судалж, ажил олгогч нарын хүс ч буй чадварлаг мэргэжилтнийг бэлтгэхэд боловсруулсан хөтөлбөр хангалттай байна уу, үгүй юү гэдгийг төгсөгчдөөсөө болон ажил олгогч нараас судалгаа авах замаар хянаж хөтөлбөрөө шинэчилдэг болжээ. Тэгвэл өнөөдөр ажил олгогч нарын **1-р хэсэг: Хилийн албаны сургуулийн сонсогч, суралцагч нарын 2015-2020 оны хичээлийн жилийн дүнгийн харьцуулсан судалгаа.**

Энэ төгсөгч нарын цэргийн мэргэжлийн хичээлийн сургалтын арга барил буруу байгаагаас шалтгаалж байх

магадлалтай гэвч сүүлийн 5 жилийн хугацаанд сонсогч нарын дүнд харьцуулалт хийвэл

Зураг 8. Хилийн албаны сургуулийн 2015-2020 оны сурлагын дүнг харьцуулсан судалгаа



Дээрх графикаас харахад сонсогчдын сурлагын амжилт, чанар сүүлийн 5 жилд

хэлбэлзэлтэй байгаа ба дунджаар амжилт-79, чанар-54.42, голч-2.45

үнэлгээтэй байна. Энэ судалгаанаас харахад суралцагч нарын чанарт онцгойлон анхаарах шаардлагатай гэж үзэж байна нөгөө талаар зөвхөн мэдлэгт суурилсан сургалт явуулаад чадвар, үр

дүнд суурилсан сургалтыг орхигдуулаад байна уу гэсэн таамаглал дэвшүүлж болох юм. Үүнд SWOT, TOWS матриц шинжилгээ хийвэл

Хүснэгт 3. Дотоод орчны шинжилгээ

Дотоод орчны шинжилгээ	Давуу тал Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн цогц чадамжид суурилсан агуулга шинэчлэлийг захиалагч байгууллага, төгсөгчдөөс авсан судалгаа, шинэчлэгдсэн хууль, эрх зүйн шаардлагад тулгуурлан, 2018,2020 онд хийсэн.	Гадаад орчны шинжилгээ	Боломж Сургалтын арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж, сурахад чиглэгдсэн ч арга зүйн үр дүнг тооцож анализ хийх.
	Сул тал Суралцахуйн болон багшлахуйн арга зүйн баримт бичиг дутмаг. Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт жигд бус, сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн баримт тодорхойгүй. Сургалтын хөтөлбөр тогтворгүй өөрчлөгдөж байдаг.		Эрсдэл Сургалтын арга зүй нь шинэчлэгдэхгүй, цэргийн сургалтын цөөхөн арга зүйг ашигладаг.

Дээрх судалгаанд сонсогчдын сурлагын ахиц амжилтад дүн шинжилгээ хийж, сурах хандлагыг төлөвшүүлэх, сайжруулах, ажлын байранд шаардлагатай цэргийн хэргийн мэдлэг ур чадварыг сонсогчийн бие даалтын цагаар олгох, сонсогчийн үнэлгээг ил тод найдвартай шударга, ижил тэгш байх нөхцөлийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч, үүссэн асуудлыг шуурхай

шийдвэрлэх, хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

2-р хэсэгт: Сургалтад хэрэглэх номын сангийн баяжилтад хийсэн судалгаа

Судалгаанд Дотоод Хэргийн их Сургуулийн төв номын сан, дотуур байрны номын сангийн сурах бичиг гарын авлагын нэрсийн жагсаалтыг ашиглав.

Зураг 9. Хилийн албаны фондын номын харьцуулсан судалгаа



Дотоод хэргийн их сургуулийн төв номын сангийн нийт номын 57.2 хувийг хууль зүйн ухааны, 17 хувийг Монголын түүх ёс заншил, 11.4 хувийг Эдийн засгийн ухаан, 9.6 хувийг Улс төр судлал, философи, гүн ухаан, 8.4 хувийг хил судлалын хичээлийн сурах бичиг, гарын авлага эзэлж байна.

Сургалтын хөтөлбөрт ашигладаг нууцын бус эдийн засгийн холбогдолтой сурах бичиг, гарын авлагын судалгааг гаргахад 6533 ширхэг сурах бичиг, гарын авлага байгаа нь Их сургуулийн номын фондын 8,4 хувийг эзэлж байна. Хилийн албаны сургуулийн нийт сонсогчдын тоонд харьцуулж тооцвол 1 хүнд 18,2 ном сурах бичиг ногдож байна. Гэвч цэргийн ухааны номын тоо нь хангалтгүй буюу 3 хүнд 1 сурах бичиг ноогдож байна.

Хилийн албаны сургуулийн нууцын номын санд Монгол Улсын “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуульд заасны дагуу “Маш нууц”-ын зэрэгт хамаарах мэдээлэл агуулагдсан мэргэжлийн хичээлийн сурах бичиг, гарын авлага багш, сонсогчдын хэрэгцээг бүрэн хангах хэмжээгээр хадгалагддаг. Нууцын номын сангийн үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулдаг бөгөөд номын фондын баяжилтыг ХХЕГ, ТЕГ-аас нэгдсэн байдлаар зохион байгуулж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьдаг. Нууцын номын сангийн талаарх мэдээлэл нь нууцын зэрэг хамаардаг тул

дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны ажилд тусгах боломжгүй юм.

Сонсогчийн дотуур байранд байрлаж буй I, II дамжааны сонсогчид тус байрны номын сангаар үйлчлүүлэх, мөн мэргэжлийн болон мэргэшүүлэх дадлага хийх үедээ хилийн анги, салбарын номын сангаар үйлчлүүлж, шаардлагатай мэдээлэл авах нөхцөл бололцоогоор бүрэн хангагдсан байдаг байна.

Цэргийн боловсрол олгох сургалтад ном сурах бичгийн тоо нь хангалтгүй буюу 3 сонсогчид 1 ширхэг ном ноогдож байгаа бөгөөд үүнээс цэргийн сургалтын талаар тодорхой хувьд нөлөөлж байгаа гэж үзэж байна.

Дүгнэлт

Монгол улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй шинэ үеийн хил хамгаалах байгууллага үүсэж хөгжсөн хугацаанд хилийн орон зайд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг гардан явуулж байна. Хил хамгаалах байгууллагын салбар, нэгжүүд тэдгээрийн бие бүрэлдэхүүн улсын хил хамгаалах үүргээ хоногийн 24 цагийн турш тасралтгүй хэрэгжүүлж байдаг. Энэ хилчдийг удирдан зохион байгуулж буй төрөл мэргэжлийн офицеруудыг 1933 оноос 2021 он хүртэл хилийн албаны сургууль нь тасралтгүй бэлтгэн гаргаж ирсэн түүхтэй байна.

Сургалтын хөтөлбөрийг үнэлэхдээ 13 асуулга бэлдэж хилийн 31 ангийн захирагчаар тандалд хийлгэхэд

сонсогчдын сурах арга барил, үйлдвэрлэлийн дадлагын үр дүн, мэргэжлийн боловсрол олгох байдал, багш нарын мэдлэг, заах арга барил, элсэгчдийн сонгон шалгаруулалт, практик сургалтын чанар зэрэг нь хангалттай сайн биш гэж үзсэн байна. Судалгаанаас харахад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа буюу мэдлэг олгож буй процессын хувьд дунд түвшинд байгаа нь мэргэжлийн хичээлийн хөтөлбөрүүд зорилгодоо хүрэх боломж оюутнууд болон нийгмийн эрэлтийг гүйцэлдүүлэх зорилгоор өөрсдийн хөтөлбөрөө үе шаттайгаар хянаж үнэлж байх шаардлагатай байна. Ийм төрлийн хяналтын ажил шинэчлэлийг хийснээр мэргэжлийн хөтөлбөрийг байнгын сайжруулалт, шинэчлэл рүү хөтлөх юм.

Нөгөө талаас нь сонсогчдоор өөрсдийг нь үнэлүүлэх судалгаанд нийт 200 гаруй сонсогчийг 10 асуулга бүхий судалгаа авахад хамгийн өндөр хувьтай нь биеийн тамир, жагсаалын бэлтгэл, цэргийн хэргийн хичээлийг 58.5 хувь нь өөрсдийгөө сайн гэж үзсэн бол гадаад хэл, цэргийн ар тал, албаны амьтдыг хил хамгаалалтад ашиглах, зэвсэг, техник ашиглах чадварын 39.2 хувь нь дунд буюу муу гэсэн хариултыг өгсөн байна. Энэ нь хилийн албаны сургуулийн сонсогч нар өөрсдийн мэдлэг, чадварыг хангалттай сайн байна гэж үзэж байгаа нь захиалагч байгууллагаас авсан судалгаатай сөрөг үр дагаварт хүрч байна. Уг судалгаанаас үзээд сонсогчдын сурлагын дүнд харьцуулсан судалгаа хийхэд сүүлийн 5 жилийн хугацаанд сурлагын чанар дунд буюу 2,6 голчтой байгаа нь суралцагч нар өөрсдийн бодит дүнгээс хавьгүй илүүд үнэлж байгаа нь сургалтын хөтөлбөрийн үр дүнд сайжруулахад сөрөг нөлөө үзүүлж болох юм.

Сургалтын үр дүнд нөлөөлж буй байдлыг зарим хэсгийг судлахын тулд харьцуулалтын аргыг ашиглан судалгаа боловсруулахад сургалтын хөтөлбөрүүдийг 2015, 2018, 2019 онуудад хөтөлбөрийн шинэчлэлт хийсний хөтөлбөрийг цаг хувиралтыг

судалж үзэхэд сүүлийн жилүүдэд хөтөлбөрүүдийн танхимын цаг өмнөх жилүүдээс 11,2 %-иар өссөн, мэргэжүүлэх дадлага 25 %-иер өссөн, албан тушаалын дадлага 5 %-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь сургалтын хөтөлбөрүүдэд танхимын цаг хангалттай мэт боловч цэргийн мэргэжил олгох сургалтыг танхимаар бус биеэр хийж гүйцэтгэх танхимын бус сургалтыг илүү оруулж өгснөөр сургалтын үр дүнд нөлөөлж болохуйц юм. Учир нь 3 удаагийн сургалтын хөтөлбөр өөрчлөгдөөд шинэчлэлт хийгээд байхад сургалтын үр дүн дунд байна гэдэг нь бидэнд танхимын бус хичээлийн цагийг нэмэгдүүлэх шаардлагатай буюу сонсогчдыг биеэр хийж гүйцэтгэх хичээлийг нэмэгдүүлэх ёстой гэж үзэж байна.

Их сургуулийн удирдлагын хувьд материаллаг болон материаллаг бус талаараа сургалтын хөтөлбөрүүдийг маш их дэмждэг нь хөтөлбөрийн санхүүжилт, номын сангийн нэг сонсогчид ногдох мэргэжлийн номын эзлэх хувийн өссөн үзүүлэлтээр тодорхой харагдаж байна.

Сонсогч, суралцагчдыг урамшууллын хувьд сүүлийн 2 жил өмнөх үеийнхээс 20-30 хувир буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь цэргийн сургалтын үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж болох юм. Учир нь суралцагч нарт өгөх сургуулийн удирдлагын мотивацжуулалт алдагдаж суралцагчдаа үнэлэх үнэлэмжийн хэлбэлзэл алдагдсанаас ялангуяа 2-3 дугаар дамжааны сонсогчдын идэвх буурснаар сурлагын амжилтад нөлөөлсөн байж болно

Судалгаанаас харахад өмнөд болон хойд хөршийн цэргийн сургаалтанд түлхүү ашигладаг арга нь рефлекс суурилсан сургалтын аргыг түлхүү хэрэглэдэг байна. Учир нь цэргийн албан хаагч эсвэл мэргэжлийн офицерууд нь нэг зүйлийг олон удаа давтан хийж тодорхой цагийн байдлуудад ажилссанаар бодит цагийн байдал буюу практикт гараад урьд өмнө тохиолдож байсан зүйл дээрээ үндэслэн

шинэ цагийн байдалд шилжүүлэн дасан зохицох зан үйлийн хэв маягийг хэрэгжүүлэн сургадаг байна. Энэ тэднийг гэнэтийн хямралд орох буруу шийдвэр гаргах, ажлын ачааллыг багасгах, мэргэжлийн ур дүйтэй болох зэрэг олон төрлийн давуу талуудтай байна.

Монгол Улсын хувьд цэргийн албан хаагчдыг сургах явцад сурган хүмүүжүүлэх технологид суурилсан ойлголтуудын дараах ангилал нь хамгийн сайн хэрэглээг олсон гэж үздэг байна. Үүнд

- Уламжлалт академик сургалт;
- Програмчлагдсан сургалт

• Шавь төвтэй сургалтын арга барилыг түлхүү ашигладаг гэвч энэ сургалтууд нь бодит амьдрал төдийлөн нийцэхгүй байгаа нь төгсөгч нарын мэдлэг чадвар хийсэн судалгаанаас тодорхой харагдаж байгаа юм.

Энэ нь хилийн албаны сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүд, сургалт, заах арга зүй, орчны хамаарал харилцан уялдаатай байна судалгаанаас харахад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа буюу мэдлэг олгож буй процессын хувьд дунд түвшинд байгаа нь мэргэжлийн хичээлийн хөтөлбөрүүд зорилгодоо хүрэх боломж бүрдүүлэх, оюутнууд болон нийгмийн эрэлтийг гүйцэлдүүлэх зорилгоор өөрсдийн хөтөлбөрөө үе шаттайгаар хянаж үнэлж байх шаардлагатай байна.

Дээрх судалгаануудыг нэгтгэн дүгнэхэд төрөөс хөтөлбөрт чиглэсэн бодлого, их сургуулийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ сайн байгаа боловч сургалтын хөтөлбөрт ногдож байгаа цэргийн мэргэжлийн хичээлийн эзлэх хувь нь бага байгаа учраас суралцагч нарын цэргийн хэргийн мэдлэг сул байна гэж товчоор ойлгож болох юм. Учир нь цэргийн мэргэжил олгох сургалт буюу ерөнхий цэргийн тактик, хилийн алба, галын бэлтгэл гэх мэт хичээлийг 100 хувь танхимын хичээлээр олгоно гэвэл өрөөсгөл ойлголт юм. Цэргийн мэргэжлийн хичээлүүдийн 70 хувийн практик эсвэл хээр, дадлага хэлбэрээр

орж байж сургалтын үр дүн сайжирна. Уг асуудлыг хөрш орнууд мэдэж байгаа учир ассоциатив-рефлекс олгох сургалтын түлхүү оруулдаг байна. Мөн улирал бүр сонсогчдыг сургуулийн удирдлагаас урамшуулж мотивацжуулах нь үр дүнг нэмэгдүүлэх боломжтой юм.

Санал

Хилийн албаны сургуулийн сонсогч нарын суралцахуйн үр дүнг үр дүнд суурилсан сургалт руу чиглүүлэхэд мэргэжлийн хөтөлбөрүүдэд өөрчлөлт сайжруулалтыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай гэж үзэж дараах саналуудыг дэвшүүлж байна.

1.Хичээлийн жилийн төгсөлд хилийн албаны сургуулийн удирдлага, багш, магистрантууд, удирдлагын академийн сонсогч, эчнээ дамжааны суралцагч, бакалаврын өдрийн ангийн сонсогч нарын хамтарсан нэгдсэн бэлтгэлийг жил бүр зохион байгуулбал дутагдаж байсан цэргийн хэргийн мэдлэг, багаар ажиллах чадвар болон захиалагч байгууллагын гол шаардаж буй дээрх 8 төрлийн мэдлэг, ур чадвар дээшлэх магадлалтай юм. Тухайн нэгдсэн бэлтгэл хичээлийг 7-14 хоногийн хугацаатай зохион байгуулж тактикийн шуурхай дадлага, тактик - жагсаалын хичээл, салбарын байлдааны буудлага, штабын нэгдсэн ба хэсэгчилсэн дадлага, цэргийн тоглоом, тактикийн аргачилсан цогцолбор дасгал, команд -штабын сургууль; команд-штабын хээрийн сургууль, тактикийн хээрийн сургууль, байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль зэрэг сургалтын хэлбэрүүд ашиглаж танхимаас хээрийн байрлалд шилжүүлэн янз бүрийн цэргийн тоглоомын дасгалууд өгч түүн дээр үргэлжилсэн цагийн байдал өгөн тасралтгүй сонсогч нарыг хөгжүүлэх мөн тодорхой цагийн байдалд, орон тооны удирдах байгууллагуудын бүрэлдэхүүний дотор ажиллаж бүхэл бүтэн албан тушаалтнуудын үүргүүдийг гүйцэтгүүлэх явдал юм.

2. Хичээллэх цагийн хуваарьт өөрчлөлт оруулах:Сургалтын

одоогийн танхимын цагийг 90 минутын хугацаатайгаар явуулж байна. Энэ нь сонсогчид хичээлдээ анхаарах, сурлагын идэвхийг өрнүүлэхэд багшийн голлох үүрэг байх боловч багш хичээлийн гол агуулгыг энэ хугацаанд өгөх бус харин сонсогчдын анхаарлыг төвлөрүүлэхэд анхаарч заах арга барилаа сонгодог дутагдал оршиж байна. Үүнийг халж 1 пар хичээлийг дундаа 10 минутын завсарлагатайгаар 45 минутын хугацаатайгаар цагийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар өөрчилж болох юм. Ингэснээр сонсогчдын идэвх сайжирна гэж үзэж байна.

3. Ассоциатив-рефлекс суурилсан сургалтын аргыг ашиглах: . Мэдлэгийг шингээж авах, ур чадвар, чадварыг бий болгох, хүний хувийн шинж чанарыг хөгжүүлэх нь энгийн бөгөөд төвөгтэй янз бүрийн холбоодын оюун санааны боловсролын үйл явц юм. Тархины бор гадаргын хувьд хамгийн энгийн рефлексээс эхлээд холболтын систем (мэдрэлийн холболт) үүсдэг. Тиймээс нэр нь ассоциатив-рефлекс ойлголт юм. Үүний үр дүнд суралцах нь эдгээр рефлекс холбоодын нөхцөлт рефлекс ба нарийн төвөгтэй гинжин систем үүсэх үйл явц гэж үздэг байна. Цэргийн хэргийн мэдлэгүүдийг давталт, бие даалт, хээрийн гаралт, цэргийн тоглоом зэрэг хэлбэрүүдээр уялдаа холбоотойгоор янз бүрийн цагийн байдалд байнга давтаж хийлгэснээр бодит цагийн байдал буюу практикт гараад урьд өмнө тохиолдож байсан зүйл дээрээ үндэслэн шинэ цагийн байдалд шилжүүлэн дасан зохицох зан үйлийн хэв маягийг хэрэгжүүлэн сургадаг байна. Энэ тэднийг гэнэтийн хямралд орох буруу шийдвэр гаргах, ажлын ачааллыг багасгах, мэргэжлийн ур дүйтэй болох зэрэг олон төрлийн давуу талуудтай байна гэж үзэж байна.

Судлаач миний биеийн дээрх дэвшүүлж буй шинэ саналыг хилийн албаны сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүд болон сургуулийн орчин нөхцөлд нэвтрүүлснээр судалгааны ажлын эцсийн гол зорилго болох

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал язгуур ашиг сонирхлыг хилийн орон зайд үнэнч шударгаар хамгаалдаг, эх оронч, үндэсний үзэлтэй, өв тэгш хүмүүжилтэй, хилийн албаны болон цэргийн хэргийн өндөр боловсрол мэргэжил бүхий офицерыг бэлтгэгдэх сургалтын үр дүнд боловсрол судлалын талаас нь тодорхой хувь нэмэр оруулах болов уу гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Аллан., Оранштейн.С., (2001), *Идэвхтэй сургалтын стратеги*. Улаанбаатар.
- Баасандорж.С., (2008), *Сургалтын арга* Улаанбаатар.
- Баттулга.М., Цацрал.П., (2021), *Хилийн албаны сургуулийн төгсөгчдийг тандах судалгаа*. Улаанбаатар.
- Бэгз.Н.,(2017), *Монголын боловсрол судлалын шинэ парадигм*. Улаанбаатар.
- Ванчигсүрэн.Д.,(2001), *Судалгаа шинжилгээний арга зүй*. Улаанбаатар.
- Галбадрах.Б.,(2013) *Чадмжид суурилсан сургалтын үнэлгээ*. Улаанбаатар.
- Дагважамц.Г., (1987), *Цэргийн хүмүүжлийн үндсэн зарчмууд*. Улаанбаатар.
- Даваа.Ж., (2017), *Сургалтын технологи*. Улаанбаатар.
- Доржбал.Г,Пүрэвсүрэн.Н.,(2004), *Цэргийн боловсрол судлал*. Улаанбаатар.
- Мягмаржав.Г., (1999), *Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс*, Улаанбаатар.
- Намжилдагва.Р., (2014), *Суралцахуй хийгээд сургахуйн онол, загварчлал*. Улаанбаатар.
- Цэвэл.Я., *Монгол хэлний товч тайлбар толь*.
- *Хилийн цэргийн 50 жил.*, (1983), Улаанбаатар.
- *Цэргийн нэр томъёоны тайлбар толь.*, (2014), Улаанбаатар.
- Монгол улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол шийдвэр. 1921-1944. I. УБ. 1995 он
- Монгол улсын хил хамгаалалтад

холбогдох тогтоол шийдвэрүүд. 1947-1951 III. УБ. 1997 он

- МУТТА. Ф-1. Хн 5

- МУТТА Ф-1. Т-3 Хн 2

- <http://www.leu.gov.mn/content/13194.shtml?shttps://news.mn/r/646702/>

- <https://dnn.mn/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB%D1%8B%D0%BD->

- Alexandra Dimitrovska, Slavko Angeleski., (2015), The impact of military education on the quality of decision making of the military leaders.

- Беспалько В.П., (2006), Слагаемые педагогической технологии. Москва.

- Гузеев В.В., (2004), Образовательная технология: отприёма до философии.

- Даль В. Толковый словарь живого великорусского языка том 4 Т. 1-4. / В. Даль. – Москва.

- Загвязинский В.И., (2001), Теория обучения: современная интерпретация. Москва